

“ИЙЗИ ТРАНСПОРТ” ХХК



**“ИЙЗИ ТРАНСПОРТ” ХХК -ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД
СҮМ, ХАЙРХАН БАГИЙН ЦАГААН ХАДАНД ХЭРЭГЖИЖ БУЙ
“ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” БҮХИЙ 14.5 ГА ТАЛБАЙТАЙ
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН
/ ААН РД: 6513107 /**

ГАРЧИГ

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн талаарх мэдээлэл	4
1.2 Төслийн товч танилцуулга.....	8
1.3 Төслийн хүчин чадал	8
1.4 Төслийн тоног төхөөрөмж	12
1.5 Төслийн дэд бүтцийн байдал	13
1.6 Төслийн хог хаягдал	13
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	17
2.1 Цаг уур	17
2.2 Агаарын чанар.....	18
Агаар бохирдуулах бодисын тооллого хийх.....	19
2.3 Гадаргын болон гүний ус	22
2.4 Хөрсөн бүрхэвч	23
2.5 Ургамлан нөмрөг.....	26
2.6 Амьтны аймаг	26
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	27
3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл ..	30
3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшихи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл	30
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	31
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлэйд үзүүлэх нөлөөлөл.....	32
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	32
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	33
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	34
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	34
3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	34
3.10 Хуримтлагдах нөлөөлөл.....	34
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ.....	36
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	38

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	43
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	44
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	52
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	55
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БУСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	58

ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ


<i>Хүснэгт 1 Гаалийн хяналтын талбайн захын цэгүүдийн солбицол</i>	6
<i>Хүснэгт 2. Тоног төхөөрөмжийн жагсаалт</i>	12
<i>Хүснэгт 3. Ажлын байрны таницуулга</i>	12
<i>Хүснэгт 4. Аюултай хог хаягдлын ангилалын жагсаалт</i>	14
<i>Хүснэгт 2. Чийг хангамж /2019 оны байдлаар/</i>	17
<i>Хүснэгт 3. Агаарын харьцангуй чийгшил /2019 оны байдлаар/</i>	17
<i>Хүснэгт 4. Дутагдал чийгшилийн сарын дундажс (мб)</i>	17
<i>Хүснэгт 5. Хоногийн хамгийн их тунадам, мм</i>	18
<i>Хүснэгт 6. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байришил</i>	18
<i>Хүснэгт 7. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн</i>	19
<i>Хүснэгт 8. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн</i>	19
<i>Хүснэгт 9. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн</i>	19
<i>Хүснэгт 10. Агаар бохирдуулагч бодис</i>	20
<i>Хүснэгт 11. Параметрийн утга</i>	21
<i>Хүснэгт 12. Шороон замаас үүсэх тоосонцрын ялгаралт</i>	21
<i>Хүснэгт 13. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт</i>	24
<i>Хүснэгт 14. Хөрсний механик бүрэлдэхүүн</i>	24
<i>Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар</i>	25
<i>Хүснэгт 16. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж</i>	25
<i>Хүснэгт 17. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа</i>	27
<i>Хүснэгт 18. Гол нөлөөллийн дүн шинжилгээ</i>	28
<i>Хүснэгт 19. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ</i>	31
<i>Хүснэгт 20. Автомашины утааны бүрдэл найрлага</i>	31
<i>Хүснэгт 21. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл</i>	35
<i>Хүснэгт 22. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	38

ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг.....	7
Зураг 2. Төслийн байришил	8
Зураг 3. Төслийн объектуудын будууч зураг.....	9
Зураг 4. Нүүрсний агуулахын зориулалт бүхий 8м өндөртэй 235м урт салхины хаалт хашаа	10
Зураг 5. Гаалийн хяналтын талбайнд байрлуулсан 200 тонны цахилгаан нүү.....	10
Зураг 6. 20 метр өндөртэй 2 ширхэг сууринуулсан гэрэлтүүлэг, камер бүхий Мобинетийн антень.....	10
Зураг 7. Байгуулсан 2.5 метр өндөртэй 700 метр хашаа.....	11
Зураг 8. Ажилчдын амьдардаг контенар хаус	11
Зураг 9. Кемпийн план зураг	12
Зураг 10. Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон Өрхийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015 стандартын шаардлага- https://fb.watch/n1CpsuPIBD/	13
Зураг 5. Жилийн нийлбэр хур тунадасны тархалтын зураг	18
Зураг 6. Автомашинаас ялгарах хаягдлын тархалт.....	20
Зураг 7. Гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцрын тархалт	21
Зураг 8. Төслийн талбайн харьялагдах сав газрын зураглал	22
Зураг 9. Төслийн хөрсөн бүрхэвчийн зураглал	23
Зураг 10. Төслийн талбайн бэлчээрийн хэв шинж.....	26
Зураг 11. Төслийн талбай орчмын амьтны судалгаа.	27
Зураг 12. Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон Өрхийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015 стандартын шаардлага- https://fb.watch/n1CpsuPIBD/	51

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн талаарх мэдээлэл



Төслийн нэр:	Гаалийн хяналтын талбай
Төсөл хэрэгжүүлэгч:	“Ийзи транспорт” ХХК Тус компани нь гадаад дотоод худалдаа, олон улсын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2019 оны 03 сард байгуулагдсан.
Ашиглах талбай:	14.5 га
Байршил:	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад Гашуун Сухайт хилийн боомтоос хойш 25км-т байрлах ба нүүрс тээвэрлэх төв авто зам дагуу 145м х 1000м хэмжээтэй 14.5га (145000m^2) талбайг хамарна.
Зорилго:	<p>Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг Цагаан хаданд тус сумын засаг даргын 2020-08-07 өдрийн А/225 тоот захирамжаар нэгж талбарын 4601010192 дугаар бүхий 14.5 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшихээр авсан болно.</p> <p>Тус компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй гаалийн хяналтын талбайн төсөл хэрэгжиж эхэлснээр:</p> <ul style="list-style-type: none">• 20-30 хүний тогтмол ажлын байр бий болох.• Нүүрс экспортлох үйл ажиллагаа, ачаа тээврийн хурд нэмэгдэхэд болон орон нутгийн болон улсын төсөвт нэмэлт орлого оруулан улс орны эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.
Төслийн үндэслэл:	Таван толгой нүүрсний орд газраас БНХАУ-руу экспортлох нүүрсний хэмжээ жил бүр тогтмол өссөөр байгаа билээ. Өнгөрсөн 2018 онд тус боомтоор 18 орчим сая тонн нүүрс


	<p>экспортолсон ба энэ онд экспортлох нүүрсний хэмжээг 25 сая тонн болгооор зорин ажиллаж байна. Энэхүү хэрэгцээг дагаад экспортын нүүрс тээвэрлэх хувь хүн, тээврийн компанийн тоо ессөөр байгаа нь замын даац хэтэрч, авто зам дээр 50-120км хүртэл урт дараалал үүсэх нөхцөл байдал тогтмол гарах болсонтой холбогдуулан Засгийн газраас дараах арга хэмжээг авч эхлээд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. 2018 оны 11-р сард Цагаан хадны гаалийн талбайнуудын үйл ажиллагааг сэргээх тогтоолыг гаргасан.2. Таван толгой Гашуунсухайт чиглэлд дахин шинээр 2 эгнээ бүхий хүнд даацын авто замыг 2018 оны 4-р сараас эхлүүлэхээр болсон.3. Цагаан хад суурышлын бүсээс Гашуунсухайт боомт хүртэлх богиных тээврийн дарааллыг багасгах зорилгоор шинэ зам барих, замын хөдөлгөөний урсгал чиглэлийг өөрчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. <p>Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нүүрсний экспортын хэмжээ, хурд сайжирч, тус суурышлын бүсэд байрлах гаалийн хяналтын талбайн эрэлт хэрэгцээ 25-30%-аар нэмэгдэж байна.</p>
Хүчин чадал:	<p>Тус гаалийн хяналтын талбай бүрэн хүчин чадлаараа ажиллахад 1 сард дунджаар 150 мянган тонн хүртэлх нүүрс хүлээн авч, гаалийн бүрдүүлэлт хийн ачиж өгөх боломжтой.</p> <p>Тус байгууллага нь хүний нөөцийн баг болон техник, технологийн нөөц баазыг хангалттай хэмжээнд бүрдүүлж чадсан бөгөөд байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүч, байнгын ажлын байртай албан хаагч, тэдгээрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, нийгмийн хангамжийн асуудлыг бүрэн шийдсэн кемп, засвар үйлчилгээний цэгийг барьж байгуулахаар төлөвлөж байна.</p>
Байгуулалтын план:	<p>Талбай дээр хийгдэж гүйцэтгэх ажлууд нь:</p> <ul style="list-style-type: none">• Талбайг тойрсон 6 метрийн өндөртэй тоос шорооноос хамгаалсан хашаа барьсан.• Нүүрс ачиж буулгах талбайд 100, 80 ган хоолойгоор хийсэн 6 метрийн өндөртэй 28 шон хоорондын зайд нь 80 метрийн зайдайгаар байрлуулж High watt Led Light S100/230 маркийн 56 ширхэг лед гэрлийг суурцуулах.• Хяналтын бүсийн ашиглагдах цахилгаан тэжээлийг Малчин ХХК-тай хамтран 11,000 Вт-ын Нарны сэргээгдэх эрчим хүчний системийг, дизель станцтай хослуулан бүрэн шийдвэрлэхээр тооцлов.• Талбайн үйл ажиллагаанд хяналт тавихаар өндөр хүчин чадал бүхий Axis фермийн 10 ширхэг хяналтын IP камерыг зохих журмын дагуу монтажлан суурцуулах.• SCS-200 маркийн 21 метрийн урт 3.4 метрийн өргөнтэй 50 кг-200тн хүртэл ачааг пүүлэх хүчин чадалтай Монгол улсын стандартчилал хэмжил зүйн шаардлага хангасан загварын туршилтаар баталгаажин Монгол улсад

	<p>ашиглахыг зөвшөөрсөн XK3190-A9 загварын авто пүүг суурилуулах.</p> <ul style="list-style-type: none">Хяналтын бүсэд ашиглагдах интернэтийг өндөр хурдны (2 Mbps) мобикомын хурдны Dedicated хуваарилалттай Vlan төрлийн радио модем суурилуулан ГЕГ-ийн сүлжээнд холбуулах.Авто пүүлэгч, гаалийн байцаагчийн ажлын шаардлага хангасан ажлын 2 ширхэг байр бэлдэх.Нүүрсний зам ба талбайг холбосон зам, талбай дотор машин явах сайжруулсан шороон зам засах.Нүүрсний овоолго бий болгох газрыг нүүрсний хучилт хийж бэлтгэх.Гаалийн хяналтын бүсийн 1.0 x 0.60 метр хэмжээтэй таних тэмдэг бэлдэж байрлуулахГаалийн хууль тогтоомж, хяналтын бүсэд мөрдөгдөх дэглэмийн тухай мөн галын анхааруулах самбарууд байрлуулах.
--	--

Xүснэгт I Гаалийн хяналтын талбайн захын цэгүүдийн солбицол

№	X	Y
1	706225.59	4719431.24
2	706509.58	4719760.67
3	706765.11	471935.31
4	706466.90	4719321.00
5	706467.50	4719316.02
6	706554.52	4719259.54
7	706558.27	4719254.73
8	706412.41	4719164.41

Зураг 1. Засаг захиргааны зураг



Зураг 2. Төслийн байршил



1.2 Төслийн төвч танилцуулга

“Ийзи транспорт” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад хэмээх газарт байрлах өөрийн эзэмшлийн 14,5 га талбайд өдөрт 5000 тн нүүрс ачиж буулгах хүчин чадалтай “Гаалийн хяналтын талбай байгуулах” төлөвлөгөөтэй байна.

Бид уг газар дээр Гаалийн хяналтын бусийн журамд нийцсэн нүүрс ачилт буулгалтын талбайд ашиглах 200 тоннын пүү, ажилчдын байр, пүүний байр, харуулын байр, моторын байр, 2.5 метр өндөртэй 700 метр хашаа, 8м өндөртэй 235м урт салхины хаалт хашаа, 20 метр өндөр 2 ширхэг цамхаг (гэрэлтүүлэг, камер болон Мобинетийн антень суурьлуулсан) зэрэг объектуудыг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглаж эхлэхэд бэлэн болгосон. Төслийн хүрээнд нийт 20-25 хүнийг ажлын байраар хангаж ажиллана.


Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий үнэлгээ хийлгэсэн бөгөөд нарийвчилсан үнэлгээ хийлгэж байна. Цаашид үйл ажиллагаандаа ногоон байгууламж орчны тохижилтонд анхаарч, холбогдох байгууллагуутдай нягт хамтран ажиллана.

1.3 Төслийн хүчин чадал

“Ийзи транспорт” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад хэмээх газарт байрлах өөрийн эзэмшлийн 14,5 га талбайд өдөрт 100-200 машин нүүрс ачиж буулгах хүчин чадалтай “Гаалийн хяналтын талбай байгуулах” юм.

Төслийн барилга байгууламжууд дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нүүрсний агуулах
- Гаалийн хяналтын талбай – 200 тонны цахилгаан пүү
- 8м өндөртэй 235м урт салхины хаалт хашаа
- 20 метр өндөр 2 ширхэг цамхаг (гэрэлтүүлэг, камер болон Мобинетийн антень суурьлуулсан)
- 2.5 метр өндөртэй 700 метр хашаа
- Нийтийн бие засах газар
- Ажилчдын байр контенар хаус
- Ариун цэврийн өрөө, дүш




Зураг 3. Төслийн объектуудын бүдүүвч зураг



Зураг 4. Нүүрсний агуулахын зориулалт бүхий 8м өндөртэй 235м урт салхины хаалт хашаа



Зураг 5. Гаалийн хяналтын талбайнд байрлуулсан 200 тонны цахилгаан пүү



Зураг 6. 20 метр өндөртэй 2 ширхэг суурилуулсан гэрэлтүүлэг, камер бүхий Мобинетийн антень



Зураг 7. Байгуулсан 2.5 метр өндөртэй 700 метр хашаа



Зураг 8. Ажилчдын амьдардаг контенар хаус

Барилга байгууламжийн зохион байгуулалт, өрөөний зайд талбайн хэмжээ

Кемпийн барилгыг ажилчдын 11 амрах өрөөнд 44 хүн амьдрах боломжтой, халуун ус, гал тогоо, хоолны заал, хурлын заал, оффисын өрөөнүүд бүхий нэгдсэн цогцолбор байдлаар байгуулсан бөгөөд нийт 480m² талбайтай.

Зураг 9. Кемпийн план зураг



1.4 Төслийн тоног төхөөрөмж

Хүснэгт 2. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Техникийн нэр	Төрөл Зориулалт	Хүчин чадал, хэмжээ	Тоо ширхэг
1	ZTE	Дугуйт ачигч	3.5м.куб	3
2	SDLG 50	Дугуйт ачигч	3,5м куб	2
3	Dell notebook	Компьютер		1
4	Dell	Компьютер		3
5	Samsung M2070	Принтер		1
6	Canon LB60/30	Принтер		1
7	Epson LQ690	Принтер		1
8	XK3190-A9	Авто жин	40м урт 200тн	1
9		Гэрлийн цамхаг	өндөр 320метр	2
10		Камерийн хяналт	пүү, талбайг бүхэлд нь хянана	10
Нийт				25

Хүснэгт 3. Ажлын байрны танилцууллага

д/д	Албан тушаал	Ажлын байрны тоо	Чиг үүрэг
1	Гүйцэтгэх захирал	1	Байгууллагын өдөр тутмыг үйл ажиллагааг удирдах
2	Менежер	1	Кэмпийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулах
3	ХАБ-ын ажилтан	2	ХАБЭ-н хяналт, эрсдлийн менежментийг хэрэгжүүлэх
4	Талбайн зохицуулагч	2	Талбайн ачилт буулгалтыг хариуцах
5	Пүүний оператор /орох, гарах/	4	Ачилт, буулгалтын тоон жинг хянах, мэдээ тайан гаргах
6	Ковш оператор	4	Ачилт буулгалт хийх
7	Гар буулгагч	5	машины тэвшийг нээх хаах, үлдэгдэл цэвэрлэх
8	Харуул	2	аюулгүй байдлыг хангах
9	Нярав	1	материал хэрэгслийг нөөцийг бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих
10	Тогооч	2	Амт чанартай хоол хүнсээр хангах
11	Үйлчлэгч	1	Амрах өрөөнүүд, оффисийн ариун цэврийг хангуулах, халуун ус, угаалга ажиллуулах

	Нийт	25	
--	------	----	--

1.5 Төслийн дэд бүтцийн байдал

Тус төслийн барилга байгууламжуудыг барих явцад байгалийн баялгаас барилгын түүхий эдийн материал болох элс, хайрга, шавар зэрэг түгээмэл тархалттай ашигт малтмалаас бага хэмжээтэй ашигласан ба ихэнх материалыг бэлэн худалдаж авсан. Төслийн барилга байгууламжуудыг барих явцад болон цаашид үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөөврийн ус ашиглаж байна.

Төслийн усан хангамж

Төслийн усан хангамжийн асуудлыг зөөврийн усаар хангаж байна.

Үнд ахуйн ус хэрэглээний тооцоо

Тус төслийн хүрээнд 25 ажиллагсад байнга ажиллаж байгаа ба нэг ажилчны хоногийн усны хэрэгцээг 20* л гэж үзвэл 500 л ус хоногт, жилд /364 хоног/ 182.5 м³ хэрэгцээтэй байна. (* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт – “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангадаг гэр хороолол – 20л/хоног/хүн)

Цахилгаан эрчим хүч

Төслийн үйл ажиллагаанд шаардагдах цахилгаан хангамжийн эх үүсвэр нь 508 кВт хүчин чадалтай F.G.Wilson дизель станц, 630KVA, 505 кВт хүчин чадалтай BAIFA VOLVO дизель станц бөгөөд энэ нь цахилгаан, дулааны хэрэгцээг бүрэн хангах боломжтой юм.

Түүхий эд, туслах материал эцсийн бүтээгдэхүүн

Төслийн үйл ажиллагаанд шаардагдах цахилгаан хангамжийн эх үүсвэр нь дизель цахилгаан станц ЭСД-100 бөгөөд энэ нь цахилгаан, дулааны хэрэгцээг бүрэн хангах боломжтой юм.

Эцсийн бүтээгдэхүүн

Төслийн үйл ажиллагааны явцад ямар нэг бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй, зөвхөн үйлчилгээний чиглэлийн объект болно.



Зураг 10. Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон Өрхийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015 стандартын шаардлага- <https://fb.watch/n1CpsuPIBD/>

1.6 Төслийн хог хаягдал

Хатуу хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас дараах хатуу хог хаягдал гарна. Үүнд:

1. Энгийн хог хаягдал – Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаядлууд болох хоол хүнсний

үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, пластмасс, төмөр, шил, яс, мод зэрэг хог хаяглууд

2. Аюултай хог хаягдал - Тус төслийн зүгээс Засгийн газрын 2018 оны 116 дүгээр тогтоолын хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт” –д заасан аюулын зэрэглэлээр шууд аюултай хог хаягдал гэж үзэх Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх тосны шүүр, тоормосны шингэн, хар тугалгатай батарей, аккумуляторын хаягдал үүсч болозошгүй байна. Бусад аюултай хог хаягдал нь хяналттай буюу аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох, аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзэх хог хаяглууд байна.
3. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн A-429/257 дугаар тушаалын хавсралтын хүрээнд Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтын 3, 8,9 заасан хог хаягдал гарахаар байна .

Хүснэгт 4. Аюултай хог хаягдлын ангиалалын жагсаалт

Хог хаягдлын эх үүсвэрийн бүлэг	Хог хаягдлын эх үүсвэрийн дэд бүлэг, бүлгийн код	Хог хаягдлын код	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын зэрэглэл	
16.Бусад хог хаягдал. (Аль ч салбарт хамарагдах эх үүсвэрээс үүсэх боломжтой хаяглууд орно)	16 01. Ашиглалтаас гарсан машин, механизмын тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал 16 03. Гологдол болон ашиглагдаагүй бүтээгдэхүүн (хүнсний бүтээгдэхүүн хамаарна)	16 01 02*	Ашиглалтаас гарсан автомашин	X	
		16 01 04*	Тосны шүүр	A	
		16 01 05*	Мөнгөн ус агуулсан эд анги	X	
		16 01 06*	Полихлорт бифенил (PCBs) агуулсан хуванцар, нийлэг эд ангийн хаягдал	X	
		16 01 07*	Тээрэмтгий шинж чанартай эд ангийн хаягдал (хамгаалалтын дэр г.м)	A	
		16 01 08*	Асбест бүхий тоormосны жийргэвч (накладка)	X	
		16 01 10*	Тоormосны шингэн	A	
		16 01 11*	Хортой нэгдэл агуулсан антифризийн (хөлддөггүй) шингэнний хаягдал	X	
		16 01 18*	16 01 04-16 01 08 болон 16 01 10, 16 01 11-д зааснаас бусад хортой эд анги	X	
		16 03 01*	Хортой бодис агуулсан органик бус хаягдал	X	
16 06. Батарей, аккумулятор		16 03 03*	Хортой бодис агуулсан органик хаягдал	X	
		16 06 01*	Хартугалгатай батарей, аккумуляторын хаягдал	A	
		16 06 02*	Никель-кадмийн батарейн хаягдал	A	
		16 06 03*	Мөнгөн ус агуулсан батарейн хаягдал	A	
		16 06 06*	Батарей, аккумуляториас ялгаж авсан электролитийн усмал	A	
16 12. Мал, амьтны сэг зэм		16 12 02*	Халдварт өвчин, хордлогын улмаас үхсэн болон зориудаар устгасан мал, амьтны сэг зэм	A	

Эх үүсвэр - (ЗГ -ын 2018 оны 116 дүгээр тогтоолын хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт” -аас)

Тайлбар :

- Аюултай хог хаягдлыг “A”, хяналтай хог хаягдлыг “X” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэнэ.
- “A” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг шууд аюултай хог хаягдал гэж үзнэ.
- “X” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох ба аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзнэ.
- Аюултай болон хяналттай хог хаягдлын код нь “*” гэсэн тэмдэглэгээтэй байна.

Хог хаягдлыг зайлцуулах арга хэмжээ

Энгийн хог хаягдал - Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлцуулах, мөрдөж ажиллах зөвлөмжийг санал болгож байна.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булашах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагатай.

2) Дараах шаардлагыг хангасан хогийн савтай болох шаардлагатай. Үүнд:

- Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;
- Галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх

3) Ханбогд сумын хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, эсвэл сум орон нутгаас зөвшөөрсөн хогийн цэгт хаях

4) Бусад :

- Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- Хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;

Аюултай хог хаягдлыг зайлцуулах

- Төсөл хэрэгжүүлэгч нь Аюултай хог хаягдлыг 180 хоног хүртэл хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно.
- Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэх.
- Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;

Шингэн хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх шингэн хог хаягдал гарна. Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас гарах шингэн хог хаягдлыг бохирын цооног байгуулж зайлцуулахаар төлөвлөсөн байна.

Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн цооногт хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц бетонон доторлогоо хийх, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэх нөхцлийг сайтар тооцож хийх нь зүйтэй. “Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах журам”-д заасны дагуу бохирын цооногийг байгуулж ашиглах шаардлагатай. Үүнд:

- Иргэн аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах гэрээ байгуулахын өмнө цооногийн байршлыг тогтоож, доторлогоо, тохижуулалтыг хийж, тээврийн хэрэгслийн зогсоолыг хатуу хучилттай болгож, гадаргын урсац зайлцуулах суваг татсан байна.
- Доторлож тохижуулсан цооногийг ашиглалтад оруулах зөвшөөрлийг сум, дүүргийн байгаль орчны болон эрүүл ахуй, халдварт судлалын хяналтын байгууллага олгоно.
- Цооногийг гэр, сууц, алхлын байшинаас 10 м-ээс доошгүй зайд газрын байршлын доод талд салхины ноёлох чиглэлийг харгалзан байрлуулна.
- Цооногийг бохир ус татаж соруулах зориулалтын хөсөг, техник хэрэгсэл хүрч очих боломжтой газарт байрлуулна.
- Цооног нь тухайн ус ашиглагчийн нэг жил хүртэлх хаягдал бохир усыг багтаах эзэлхүүнтэй ялаа, шавьж орохоогрүйгээр хийгдсэн байна. Цооногийн эзлэхүүнийг тооцоход хаях бохир үсны хэмжээ, бохир усыг татаж зайлцуулах хугацаа, гэнэтийн оссл, аваарын үед гарах бохир үсны хэмжээг харгалзана.
- Цооногийн гадна талыг гэрэлтүүлж, цооногоос сууц, байшин хүртэл зам тавьж, цооногийн амсрыг таг сараалжтай болгож ашиглахад тохиромжтой байхаар тохижуулна.
- Цооногийн орчны нөхцлөөс хамааруулан эргэн тойрныг тэгшлэх, бороо, хурын ус чийг шүүрч нэвтрэхээс сэргийлэх, шаардлагатай бол хатуу хучилт хийнэ.
- Цооногийг төмөр бетон, бетон зэрэг ус нэвчихгүй материалыар доторлоно. Доторлогооны зузаан нь цементийн марк (400-гаас доошгүй), бетоны марк, бэлтгэх технологи цооногийн гүн, эзлэхүүн, хөрсний үсны байршлын гүнээс хамаарч 10 см-ээс багагүй байна.
- Цооногийн доторлогооны гадна талын хөрсний устай харьцах хэсгийг ус нэвтрэхгүйгээр хамгаалсан байна.
- Цооногийн доторлогоог модоор хийхийг хориглоно.
- Цооногт хатуу хог хаягдал хаяхыг хориглоно.
- Цооног, түүний орчимд жил бүр тогтоосон хугацаанд хортон, шавьжны устгал хийнэ.
- Цооногийн эзлэхүүмий 70-80 хувь дүүрсэн үед зориулалтын техник хэрэгсэлээр соруулж тогтоосон цэгт зайлцуулж хаяна.

Хийн хаягдал Нүүрс ачиж буулгах талбай орчимд хүнд болон хөнгөн даацын автомашин, механизмуудын утая нь хийн хаягдлын нэг гол үүсгүүр болох юм.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Цаг уур

Өмнөговь аймгийн нийт нутаг хуурай уур амьсгалтай бүсэд багтана. Агаар хуурай, хөрснөөс уурших чийгийн нөөц бага учраас жилийн дулааны улирлын харьцангуй чийгшлийн дундаж 29-50 %, өвлийн улиралд 50-75 %-аас хэтэрдэггүй. Өдрийн 13 цагийн харьцангуй чийгшил 20 % хүрнэ. Зарим өдөр 9-11 % хүртэл буурах явдал ч бий. 30 %-аас бага чийгтэй өдрийн тоо жилийн дулааны улиралд төвийн болон хойд, зүүн талаар 85-аас бага, өмнө талаараа 85-100 байгаагаас үзвэл агаар нэлээд хуурайг харуулна. Агаар нэн хуурай учир хур тунадасны хэмжээ ерөнхийдөө бага юм. Нутаг дэвсгэрийн чийг хангамж, агаарын харьцангуй чийгшил, дутагдал чийгшлийн хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5. Чийг хангамж /2019 оны байдлаар/

Д/д	Станц, харуул	Cap				Дундаж
		5	6	7	8	
1	Ханбогд	0.2	0.2	0.4	0.5	0.4

Хүснэгт 6. Агаарын харьцангуй чийгшил /2019 оны байдлаар/

Д/д	Станц, харуул	Cap											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Ханбогд	-	-	-	35	34	36	44	40	40	-	-	-

Хүснэгт 7. Дутагдал чийгшлийн сарын дундаж (мб)

д/д	Станц, харуул	Cap							
		4	5	6	7	8	9	10	
1	Ханбогд	6.6	11.7	14.8	13.8	12.5	9.7	6.2	

Хур тунадас


Аймгийн нийт нутгаар хур тунадас шингэн ба хатуу төлөвтэй унана. Олон жилийн дунджаар Ноён, Гурвантэс, Ханхонгор, Булган, Даланзадгад, Ханбогд суманд 102.1-132.9 мм тунадас, Баян-Овоо, Номгон суманд 63.2-70.9 мм, бусад суманд 80-100 мм тунадас унадаг. Жилд унах тунадасны хэмжээ жил бүр ижил байдаггүй, зарим жил олон жилийн дундаж хэмжээнд орж байхад зарим жил олон жилийн дундаж хэвийн хэмжээнээс харьцангуй их, бага янз бүр ордог. Тэр ч байтугай 1 хоногт жилд орох тунадасны ихэнх нь орж байсан тохиолдол байдаг. Тухайлбал, Даланзадгадад 1977 онд 235.3 мм, Номгонд 1969 онд 156.9 мм тунадас жилдээ орж байсан бол Даланзадгадад 1956 оны 8-р сарын 5-нд 137.8 мм, 1979 оны 6-р сарын 29-нд 53.5 мм тунадас 1 хоногт орж байжээ. Гэтэл Даланзадгадад 1944 онд 51.6 мм, Номгонд 1980 онд 9.1 мм тунадас жилд оржээ. Үүнийг олон жилийн дундаж хэвийн хэмжээтэй харьцуулбал 58.4-87.2 %-аар бага байна. Далайн түвшнээс дээш 1800 метрийн түвшинд 75-100 мм, 1000-1400 м түвшинд 50-75 мм, 1000 м-ээс доош нутагт 50 мм-ээс бага тунадасын уналтыг дараах хүснэгтээр харуулав.

Олон жилийн дунджаар жилд Ханбогд суманд 102.3 мм тунадас унадаг байна. Харин тус сумын нутгаар дулааны улиралд жилийн нийт хур тунадасны 96.2 хувь нь унадаг байна.

Хүснэгт 8. Хоногийн хамгийн их тунадам, мм

Д/д	Станц, харуул	Cap	Жил											
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Ханбогд	2.5	1	1	11.5	12.5	12	22.2	27	10.9	4.6	4.2	0.3	27

Зураг 11. Жилийн нийлбэр хур тунадасны тархалтын зураг



Жилд унах тунадасны хэмжээ жил бүр ижил байдаггүй, зарим жил олон жилийн дундаж хэмжээнд орж байхад зарим жил олон жилийн дундаж хэвийн хэмжээнээс харьцангуй их, бага янз бүр ордог. Далайн төвшнөөс дээш 1800 метрийн түвшинд 75-100 мм, 1000-1400 м түвшинд 50-75 мм, 1000 метрээс доош нутагт 50 мм-с бага тунадас унах магадлал 80% байна. Иймээс ургамлын чийг хангамж туйлын муу ажээ.

2.2 Агаарын чанар

Төслийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

Хүснэгт 9. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байришил

Агаар		Координат	Цэг сонгосон үндэслэл	Дээж авч буй фото зураг
1	1-p цэг		Өмнө хийгдсэн хяналт-шинжилгээний үр дүнтэй харьцуулах	

Хяналт шинжилгээний үр дүн

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн өрөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 10. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/
1	Ажлын талбай	0.300
2	Гадна талбай	0.480
	Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016	0.500

Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 11. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	NO ₂ (Азотын давхар исэл мг/м ³)	SO ₂ (Хүхэрлэг хий мг/м ³)
1	Ажлын талбай	0.066	0.065
2	Гадна талбай	0.085	0.115
	Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016	0.200	0.450

Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба 16 цагийн дундаж үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Хүснэгт 12. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
1	Ажлын талбай	56
2	Гадна талбай	61
	Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 дБ (А), 16 цагийн дундаж	60

Агаар бохирдуулах бодисын тооллого хийх

2019 онд БОАЖЯ-наас гаргасан Агаар бохидуулах бодисын хаягдлын тооллого хийх аргачлалыг ашиглаж хялбарчилсан аргаар автомашинаас ялгарах хаягдлыг тооцох, шороон замаас дэгдэх тоосонцрын хаягдлын коэффициентыг тооцов.

Хялбарчилсан аргаар автомашинаас ялгарах хаягдлыг тооцох

Шланзны шатахуун зарцуулалт 17.5 л/цаг, бага оврын ачааны машины шатахуун зарцуулалт нь 12.5 л/цаг байна. Эдгээр тээврийн хэрэгсэл тус бүрийн хийн ялгаралтыг дараах томъёогоор тооцно. Эдгээр нь машинууд нь дизель учраас зарцуулалтын хэмжээ бага оврын ачааны машины хувьд 57.5 гр/км, том оврын шланзын хувьд 240 гр/км байна.

$$E = EF * EC$$

Энд

E- тухайн бодисын ялгаралтын хэмжээ, гр

EF- бохирдуулагчийн ялгаралтын фактор, гр/кг

EC- түлш зарцуулалт, кг


Ачаа ачсан шланз 60 км/цаг хурдтай явахад түлш зарцуулалт нь 611.8 гр/км * 60 км/цаг = 36,708 гр/цаг буюу 36.7 кг/цаг юм.

Хүснэгт 13. Агаар бохирдуулагч бодис

№	Бодисын нэр	Нэгж ялгаралт, гр/кг	Ялгаралтын хэмжээ, гр/с	
			Шланз	Hinno 20 тн даацтай
1	Нүүрстөрөгчийн исэл	7.58	0.051	0.118
2	Азотын давхар исэл	33.37	0.222	0.519
3	Нүүрстөрөгч	3169	21.127	49.296
4	Хүхэрлэг хий	0.003	0.000	0.000
5	Хөө тортог	1.92	0.013	0.030
6	Хар тугалга	0.000052	0.000	0.000

Тухайн тээврийн хэрэгсэл тус бүрийн хөдөлгүүрийн шаталгаас үүсэх хийн хаягдлын оронзайн тархах тархалтыг бохирдуулагч бодис тус бүрээр тооцоолоход NOx-oos бусад элементийн хувьд зөвшөөрөгдөх агууламжаас бага байна. NOx-ийн агууламж 15 м зайд 49 мкг/m³ буюу зөвшөөрөгдөх агууламжтай тэнцүү болно.

Зураг 12. Автомашинаас ялгарах хаягдлын тархалт



Шороон замаас дэгдэх тоосонирын хаягдлын коэффициент тооцох

Шороон замаар тээвэрлэлт хийх үеийн PM10 тоосонцрын ялгаралтын хэмжээ нь хээрийн хэмжилтийн үр дүнтэй шугаман хамааралтайг доорх тэгшитгэлээр үзүүлсэн байна.

$$E = k \left(\frac{s}{12}\right)^a \left(\frac{W}{3}\right)^b$$

E	- ялгаралтын хэмжээ, (lb/VMT)
S	- гадаргуугийн тоосонцрын агууламж, (%)
W	- тээврийн хэрэгсэлийн жин, тонн

K, a, b - эмпирик тогтмолууд /Guidance on Estimating Road Dust Emissions from Industrial Unpaved Surfaces/

Ялгаралтын хэмжээ нь 1mile тээвэрлэлт хийхэд ялгаруулах тоосонцрын / 1lb/ хэмжээг илэрхийлдэг. Нэгжийг 1 гр/м-с хөрвүүлж дараах байдлаар бичив.

$$E = \frac{1.36}{u} k \left(\frac{s}{12} \right)^a \left(\frac{W}{3} \right)^b$$

U - тээврийн хэрэгсэлийн хурд, м/с

Хүснэгт 14. Параметрийн утга

Тогтмол	PM _{2.5}	PM ₁₀	TPM
k	0.042	0.423	1.381
a	0.9	0.9	0.7
b	0.45	0.45	0.45

Тээврийн хэрэгслийн дундаж хурд 50 км/цаг буюу 13.8 м/с, машины жин 20 тн байна. Шороон замаас авсан шинжилгээний дүнгээр тоосонцрын агууламж 39.5% бөгөөд энэ утга нь тээвэрлэлтийн нөлөөнд бага өртсөн шороон замаас авсан дээжийн үр дүн юм. Хэрвээ тээвэрлэлтийн нөлөө ихсэж хөрс элэгдэлд орсноос хөрсөнд агуулагдах тоосонцрын хэмжээ нэмэгдвэл ялгаралтын хэмжээ шугаман хамаарлаар нэмэгдэнэ.

Хүснэгт 15. Шороон замаас үүсэх тоосонцрын ялгаралт


Үзүүлэлт	PM _{2.5}	PM ₁₀	TPM
Ялгаралт, гр/м·с	0.041	0.41	1.06

Шугаман эх үүсвэрээс агаарт тархах бохирдуулагч бодисын агууламжийг дараах томьёогоор олов / (Gilbert, 2003)/.

$$C(x) = \frac{2q}{\sqrt{2\pi}\sigma_z u}$$

- | | |
|------------|---|
| C(x) | - тоосонцрын агууламж, мгр/м ³ |
| q | - ялгаралтын хэмжээ, гр/м·с |
| σ_z | - дисперсийн параметр |
| u | - салхины хурд, м/с |

Зураг 13. Гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцрын тархалт



Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж 300 м зайд 103 $\mu\text{g}/\text{m}^3$ байна.

Дүгнэлт, зөвлөмж

Төслийн эзэмшил талбай болон гадна талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

2.3 Гадаргын болон гүний ус

Ус зүйн сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд Галба Өөш Долоод говийн сав газарт багтдаг байна. Гадаргуугийн усан сүлжээний хувьд төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах бөгөөд гадаргуугийн байнгын усан сүлжээ хөгжөөгүй, газрын гадаргын усаар нэн ядмаг нутаг юм. Нутгийн иргэд үндны болон ахуйн хэрэглээний усаа гар худгаас хангадаг боловч эдгээр худгуудын ус нь хатуулаг өндөртэй, бага гүнтэй, үндарга багатай байдаг. Талбайн хэмжээнд Хөх овооны ус, Эхэн хаяаны болон Адаг хаяаны ус гэсэн турван гар худаг байдаг. Хур тунадас ихтэй жил жижиг нуур, тойрмууд бий болох боловч бүгд намар болоход ширгэнэ. Талбайн гадна, зүүн өмнө 2 өрөмдмөл худаг гаргасан байдаг нь өнөө хүртэл ашиглагддаг бөгөөд талбайгаас 10 км орчим зйтай өрөмдмөл худгаас өрөмдлөгийн усаа зөөврөлөн авч байсан.

Зураг 14. Төслийн талбайн харьялгадах сав газрын зураглал

Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн нутагт хэрэгжих төслийн сав газрын ангилаал



Гидрогеологи.

Гол мөрний сүлжээний нягтшилын хувьд 1.000 м² талбайд оногдох гадаргуугийн урсац 50 км-ээс бага. Уг талбайн баруун урд талын буланд Эхийн баян худаг байрлах ба худгийн амсрын өндөр далайн түвшнээс дээш 1398 метр, гүн нь 2 метр, 210 л/ц хэмжээний ундаргатай.

Төслийн талбайн хэмжээнд гадаргуугийн ил урсац, булаг, шанд, рашаан болон гол горхи байхгүй болно.

Төсөл хэрэгжих талбайн хувьд:


Уг төслийн талбай нь цэвэр усан хангамжийн хувьд гэрээт худгаас зөөврөөр авч хангадаг. Усны шинжилгээний дүнгээр химиин бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд нэн цэngэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Үндны усны стандарт MNS900:2005” –ын шаардлага хангаж байна.

2.4 Хөрсөн бүрхэвч

Байгаль-газарзүйн нөхцөл, хөрсөн бүрхэвчийн хэв шинж

Тус төслийн талбай нь байгалийн мужалын хувьд Төв Азийн өндөрлөг тал хотгор, уулт их мужийн Говь-Алтайн бэлэрхэг уулын мужийн Говь-Алтайн зүүн хэсгийн бэлэрхэг уул бүхий умард цөл, заримдаг цөлийн дэд мужийн өмнөд хуурай хээр, умард хуурай хээр, уулын нуга бүхий цөлжүү хээрийн районд хамаарна.

Зураг 15. Төслийн хөрсөн бүрхэвчийн зураглал



Ажлын явцад энд тогтвортсон хөрсний шинж чанарыг тодорхойлохын тулд 2 цэгт хөрсний зүсэлт хийж, морфологи шинж чанарын бичиглэл үйлдэн, хөрсний дээж авч хими-физик, механик бүрэлдэхүүний болон хөрсний бохирдолтын шинжилгээнд хамруулав /”Нарт шуун консалтинг” лаборатори/. Талбайн хэмжээнд заримдаг цөлийн хөрс зонхилж, цөлийн хөрс бага хэмжээгээр тархаж нийт 2 хэв шинж бүхий Нам уул-ухаа толгод болон Тал газар-хөндийн хотгорын хөрс, 15 төрөлд хамарагдах хөрс ихэнхдээ хоршил хөрс үүсгэж тогтвортжино.

Хүснэгт 16. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

Зүсэлт	Гүн, см	pH H_2O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	Ca CO_2 , %	Солилцох суурь, мг- экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр		
							Ca+ Mg	Ca	Mg	P_2O_5 , K_2O		
1	0-20	8.40	0.114	0.06	1.00	0.30	13.1	10.4	2.7	1.6	14	

Химиийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд шултлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ дунд зэрэг, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, солилцох сууриас Ca хангалттай, Mg хангалттай агууламжтай мөн хөдөлгөөнт фосфор, калийн агууламж бага байна. Хөрсний үргжил шимийн түвшин бага байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

Хүснэгт 17. Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлт	Гүн, см	Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	0-20	52.2	29.5	7.9	1.9	6.3	2.2	10.5

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 18. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар

Хөрсний шинж чанарын үзүүлэлт		Механик бүрэлдэхүүн		
		Элсэнцэр ба хөнгөн шавранцар	Дунд шавранцар	Хүнд шавранцар, шавар
1	Боловсруулалт	++	+	- -
2	Тэжээлийн бодис агуулалт	- -	+	++
3	Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт	-	++	+
4	Хоруу бодисын хуримтлал	-	++	++
5	Ус агуулалт	- -	++	++
6	Ургамал ус нийлүүлэлт	-	+	-
7	Механик шүүлт	+	+	-
8	Физик-химийн шүүлт	- -	++	+
9	Ус шүүлт	++	0	- -

*++маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, - - нэн хангалтгүй

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэнцэр ба хөнгөн шавранцар хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш сайн гэсэн үзүүлэлттэй байна.

Хөрсний бохирдол

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 1 дээж авч “Нарт шуун консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжилүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 19. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

№	Үзүүлэлт	Агууламж мг/кг	Хөрсний бүрэлдэхүүн			Хөрсний хүнд агууламж, % металлын агууламж		
			Шавар лаг	Шавран цар	Элсэрхэг	Зөвшөө рөгдөх дээд хэмжээ	Хортой агууламж	Аюултай агууламж
1	Никель (Ni)	10.2	150	100	60	150.0	1000.0	1800.0
	Кадми (Cd)	ND	3	2	1	3.0	10.0	20.0
	Хар тугалга (Pb)	1.40	100	70	50	100.0	500.0	1200.0
	Цайр (Zn)	32.6	300	150	100	300.0	600.0	1000.0
	Хром (Cr)	10.2	150	100	60	150.0	400.0	1500.0
	Зэс (Cu)	24.4	100	80	60	100.0	500.0	1000.0

Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850:2019) Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис,


элементуудийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх, хортой болон аюултай агууламжаас доогуур буюу хөрс бохирдолгүй байна.

2.5 Ургамлан нөмрөг

Ботаник газар зүйн мужлалтаар төсөл хэрэгжүүлэх газар нь Төв Азийн дэд их мужид хамаарах говийн төв мужийн (Алашаа говь) нутаг дэвсгэр дээр байрлаж байна. Цөлжүү хээрийн ба заримдаг цөлийн ланшдафт ноёрхох учир энэ бүс нутгийн ургамал амьтны аймаг өөрийн өвөрмөц онцлогтой. Тухайлбал харгана бүхий агы-хазаар өвс-хялганат, чулуусаг алаг өвс-агь ерхөг-хялганат, баглуур хялганат, баглуур-таана-хялганат хэв шинжийн ургамалшилтын багагүй холилдсон хэв шинжтэй. Тархсан ургамал, хөрсний байдлаас шалтгаалан дагалдаж амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн хэв шинжээ олсон байдаг.

Энэ тойрогт газрын зонхилох өндөр 1300-1700 м, өмнөд хэсгээрээ 700-800 м байдаг. Галба Өөш Алашаа говьд тойргийн хойд хэсгээс урагшлахад намсдаг хэвгий гадаргатай. Энэ газрын гадаргын хувьд бэрэг уулс, хотгор хотос, тойром, цав толгод, ухаа гүвээ ээлжлэн солигдохын зэрэгцээ умраас өмнийг чиглэсэн сайр, садаргууд олонтой юм. Энд элсэнцэр цөлөөс гадна чулуурхаг цөл нэлээд их тааралдана.

Зураг 16. Төслийн талбайн бэлчээрийн хэв шинж



Бор бударгана, баглуур, хойрго, хотир (нохой шээрэн), шар мод, боролзой, улаанбударгана, заг, хармаг ээлжлэн зонхилогчоор солигдоно. Марцлаг элстэй хотгороор нь сибирь хармаг оролцсон загт цөлтэй, манхан элстэй газраар нь *Hedysarum fruticosum*, *H. scoparium*, *Atraphaxis frutescens*, *Caragana Pungei*, *C. Korshinskyi* зэрэг сөөглөг, *Psammochloa villosa*, *Pugionum cornutum*, *Agriophyllum pungens* зэрэг өвслөг ургамал оролцсон элссэг сөөгөн бүлгэмдэл, сүл ширэгжсэн довцог элстэй газраар нь шаваг-сөөг (*Artemisia shphaerocephala*, *Tamarix ramosissima*, *Nitraria sibirica*)-т эвшил тохиолдоно. Гуравдагчийн элсээрхэг-сайргархаг тэгш, талархаг газраар нь хойргот, улаанбударгана, хотир буюу нохой шээрэн (*Zygophyllum xanthoxylon*)-т, сэдэргэнэ (*Convolvulus Gortschakovii*, *G. tragacanthoides*)-т цөл тааралдана. Бээрэг уулсын налгар хажуу, бэл дагууд баглуур - өдлөг хялгана (*Anabasis brevifolia* + *Stipa gobica* + *S. glareosa*)-т, бор бударгана (*Salsola passerina*)-т цөлтэй. Толгод, намхан уулс, цав, толгодын хажуугаар хэсэг хэсэг газарт элдэв сөөг, сөөгөнцөр (*Sympetrum Regeli*, *Zygophyllum xanthoxylon*, *Salsola laricifolia*, *Amygdalus mongolica*, *Atraphaxis frutescens*, *Caragana stenophylla*, *Gymnocarpus Przewalskii*, *Anabasis brevifolia*) [Өлзийхутаг, 1988]

2.6 Амьтны аймаг

Төслийн талбай орчимд манай орны целийн бүсийн нэгэн адил шавжаар хооллодог амьтад ялангуяа мэрэгчид ихээхэн тохиолдоно. Тэнд бас туурайтан амьтдын зүйлийн тоо олон юм.

Түүнчлэн жороо тоодог, монгол хулан жороо, цөлийн чогчиго, ногтруу болон бусад зарим махчин шувууд олноор амьдардаг.

- ✓ Амьтны аймгийн хувьд тал хээрээс цөлөрхөг хээрийн хэв шинж рүү шилжиж буй завсрын бүсэд оршино. Иймд дээрх хоёр хэв шинжийг төлөөлөх амьтад тохиолдож байлаа. Ховор, нэн ховор амьтадаас цагаан зээр, илдэг шонхор зэргийг дурдаж болно

Зураг 17. Төслийн талбай орчмын амьтны судалгаа.



Энэхүү нутаг элсэн цөл.gov, уул нуруудын бүс нийлэх учир мөлхөгчид, хэвлээр явагчдаар баян бөгөөд шавжийн тархац сарнимал, хоргодмол ба шөнийн амьдралтай, элсэрхэг, давсархаг орчинд зассан зүйлүүд элбэг байдгаараа онцлог. Хар цох эрс давамгайлж, царцаа шоргоолж, шорлон -ийн овог болон шөнийн эрвээхэйн олон бүлэг, ялангуяа бүгэг эрвээхэй элбэг байна. Шавжийн тоо нийтдээ олон боловч амьдралынх нь нуугдмал хэлбэрээс болоод үл анзарагдаж хаврын идэвхжилийн үе сүл илэрнэ. Энэхүү үнэлгээнд “Улаан номд”-д орсон амьтад болон зарим ховор, хортой амьтдын талаар тодорхойлохыг гол зорилго болголоо. Тухайлбал тус орд газрын хүрээнд “Улаан ном”-д орсон хөхтөн амьтан 7 байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 20. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа

Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Сөрөг Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад				
Шатах тослох материал, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал голын ус болон хөрсөнд шингэх	Гүний ус, голын ус, газрын хөрс, ургамал, амьтан, ус, агаар	Төслийн талбай	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
Усны нөөц хомсдох	Гүний ус	Төслийн талбай (нөөц хомсдох)	Бага	Төсөл хэрэгжих хугацаанд
Зам, жим харгуй ихсэх	Агаар, хөрс, хүн, амьтан, ургамал	Авто зам түүний оир орчим	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
Хоёр. Бүтээн байгуулалтын явцад				
Ногоон байгууламж байгуулах	Газрын хөрс, амьтан	Төслийн талбай	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
Цементэлсэн ил зогсоол байгуулах	Геологийн тогтоц, газрын хөрс, ургамал, амьтан, агаар	Төслийн талбай	Их	Төсөл хэрэгжих хугацаанд

Хүснэгт 21. Гол нөлөөллийн дүн шинжилгээ

Нөлөөллийн ангиалал	Гол нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн Үргэлжлэх хугацаа
1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл • Бодирдуулах • Эвдэх	<ul style="list-style-type: none"> Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бодирдог. Том хүнд даацын машинууд дураараа сэлгүүцсэнээс газрын хөрс элэгдэх хамарагдаж байна. 	Төслийн эдэлбэр газрын хэмжээ (100000 м^2)	Хөрс бодирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их	Төсөл хэрэгжих хугацаанд

	<ul style="list-style-type: none"> • Доройтуулах 	<ul style="list-style-type: none"> • Төсөл орчмын хөрс элэгдэлд орох, дагтарших, ургамлын төрөл зүйл хомсдох зэрэг хамарагдаж байна. 		ХЭМЖЭЭТЭЙ байна.	
2. Гүний усанд үзүүлэх нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Нөөцийг бууруулах 	<p>Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгараах</p> <p>Газрын гүний ус ашигладаг учраас нөөцөд бага зэрэг нөлөөлнө.</p>		Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Амьдрах орчинг хуваах • Амьдрах орчинг доройтуулах • Амьдрах орчинг хомсдуулах • Нөөцийг бууруулах 	<p>Төслийн барилга байгууламжийг барих үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох</p> <p>Үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлцуулахгүй удаах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох</p>	Төслийн эдэлбэр газрын хэмжээ (100000 м ²)	Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
4. Агаарт үзүүлэх нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Тоос 	Нүүрс ачиж буулгах болон Хүнд даацын автомашинууд нүүрс тээвэрлэх ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг.		Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	Төсөл хэрэгжих хугацаанд

		Төслийн эдэлбэр газрын хэмжээ (100000 м ²)	их зэргийн эрчимтэй байна.	
5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс • Хамгаалах Нүүлгэн шилжүүлэх	-	-	-	-

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөгсийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь үйлчлүүлэгчдийн хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл

- Барилгын материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, барилгыг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах
- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшихи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, явган хүний жим зам тавих, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолддолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Барилга байгууламж барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай.

Ашиглалт жигдээрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай
уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ашиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс
дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын
хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн,
хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид дайжих, бут өвс ургамал механик гэмтэлд өртөх
гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг
хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй
хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт
дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах
шаардлагатай.

3.3 Төслийн агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн явцад агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь автомашины утаа, санамсар
болгоомжгүйгээс үүссэн нүүрсний тортог, нүүрс ачиж буулгах процесс үүнээс үүсэх хийн хаягдал,
тоосжилт байх боломжтой юм. Тоосжилтын эх үүсвэрүүд нь:

Төслийн талбайд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тухайн орон нутгийн
тоосжилтийн түвшинг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болох бөгөөд агаарт дэгдэж буй тоосны улмаас
үзэгдэх орчин багасаж осол, аваар гарч болзошгүй. Тоосжилтын улмаас төслийн ажилчид, ойр
орчмын иргэдийн эрүүл мэнд болон эргэн тойрны байгаль орчинд зохих хэмжээгээр нөлөөлөх учир
төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч буй тоосжилтийг бууруулах арга хэмжээнүүдийг авч
хэрэгжүүлэх шаардлагатай. Төсөл хэрэгжих орчин нь өнөөгийн байдлаар хүн, амьтан, ургамалд
нөлөөлөхүйц агаарын ямар нэгэн бохирдолгүй байна.

Хийн хаягдаас үүсэх гол сөрөг нөлөөлөл

Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл
оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт
цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт
бодис ялгаруулна. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин $q=0.725$, дизель $q=0.825$) бодож,
түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашины
утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлоходоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба
азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт
болгодог.

Хүснэгт 22. Автомашин асаалттай байх утасны ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	Автомашин асаалттай, сүл зогсолттой байх үед	Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)	Машин тойргоор эргэх үед	Машин хурд саарч байх үед (60 км/цагаас доош)
CO (%)	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
HC, C ₆ H ₁₄ (ppm)	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
NO _x (ppm)	10 – 50	1000 - 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав.
Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын
үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

Хүснэгт 23. Автомашины утааны бүрдэл найрлага

№	Бүрдэл	Хөдөлгүүрийн төрөл		Тайлбар
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	Хоргүй
2	Хүчилтөрөгч (%)	0.3-8	2-18	Хоргүй
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	Хоргүй
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	Хоргүй
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	Хортой
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	Хортой
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	Хортой
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	Хортой
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	Хортой
10	Хөө тортог (г/м ³)	0-0.44	0.01-1.1	Хортой
11	Бенз (а) пирен (г/м ³)	<0.00002	<0.00001	Хортой

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

3.4 Төслийн газрын гадарга, хэвлэйд үзүүлэх нөлөөлөл

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлэлийн бага зэрэг эвдрэлтэй, Харин шороон замын хөрс машин техникийн нөлөөгөөр хүчтэй элэгдэл эвдрэлд орсноос хөрсний чулуужилт ихэссэн, зам дагуу тоосжилт ихтэйгээс ургамлан нөмрөг тоосжиж талхлагдсан зэрэг өөрчлөлттэй байна.

⊕ Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Барилга барих явцад барилгын суурь ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлэй бохирдох
- Болзошгүй тохиолдоор нүүрстэй холбоотой гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

3.5 Хөрсон бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн хашаан доторх хөрсний байгалийн элэгдэл эвдрэлийн үйл явц харилцан адилгүй хэлбэрээр тохиолдох ба хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс хүчтэй эвдрэлд орсон газар байхгүй. Харин шороон замын хөрс машин техникийн нөлөөгөөр хүчтэй элэгдэл эвдрэлд орсноос хөрсний чулуужилт ихэссэн, зам дагуу тоосжилт ихтэйгээс ургамлан нөмрөг тоосжиж талхлагдсан зэрэг өөрчлөлттэй байна.

Хөрс элэгдэж эвдрэх, бохирдох нөлөөлөл агуулахыг барьж байгуулах үед болон салаа зам гарах, хөрс хуулах, түрэх, овоолго хийх, хучилт хийх, суваг шуудуу далан, барилга байгууламжийн ажлын үед хөрс, гадаргын урсцад өөрчлөлт орж хөрсний эвдрэл үүсэх бөгөөд үүнд бас газрын гадаргын хэвгий, хөрсний шинж чанар, гадаргын урсац, ургамалжилт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлнө.

- Төслийн хашааны гадна, дотор талбай нүүрс тээврийн гаралтай орчны хөрс бохирдоно. Мөн хөрсөнд эдгээр бохирдол нэвчих талтай.

- Хамгаалалтын сахиул айл, агуулахын байр талбай, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Хөрс их хэмжээгээр эвдэрч, бүтэц шинж чанараа алдан ургамлан нөмрөгөө устгуулах ба улмаар хөрснөөс хийсэх шорооны хэмжээ ихсэж цөлжилтийн үйл явцыг түргэсгэх болно.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Ургамлан бүрхэвч нь мал болон зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс үүсгэгч, бэхжүүлэгч экосистемийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Ургамал нөмрөгийн талхагдал дунд зэрэг буй энэ орчимд хүн болоод техникийн нөлөөтэй талхагдалд нэлээд орсон байна.

Ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүд нь шороон зам, машин, хүний үйл ажиллагаанаас уг талбайнуудын ургамлын нөмрөг маш бага байна. Бүр мөсөн устах ургамлаас гаднах талбайн ургамлууд тоосжилт ба талхагдлаас шалтгаалж ургац бүтээмж доройтож, шарилж, лууль зэрэг хүмүүнсэг ургамал нэмэгдэх сөрөг нөлөөтэй. Үүнээс гадна барилгын ажлын явцад ургамлын нөмрөгийн болзошгүй хувьсал өөрчлөлт нь дараах хүчин зүйлээс шалтгаална. Үүнд:

- Хэт хуурайших, усан хангамж багасах, үер усны аюул нэмэгдсэнээс хөрсөн орчин өөрчлөгдөх хандлагатай болсон.
- Үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч бие эрхтэнд шороон тоос цугларч үйлдвэрийн болон түүний ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Ургамлын ургац, үйл ажиллагаа явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй.
- Ургамлын бүрхэвч муудах устах зэргээс өвсөн тэжээлтэн амьтад устаж, тэдгээрийг барьж иддэг махчин амьтад ч дүрвэн зайлна.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,

- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох баа ёөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын ургамал механик гэмтэлд өртөх

3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Тус төслийн талбай нь амьтны аймгийн хувьд төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн суурин газар амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Төслийн барилга байгууламжийг барих үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох, дараа нь үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлзулахгүй удаах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Техникийн шатах тослох материал асгараах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устах, хордох
- Төслийн барилгын ажлын үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.8 Гадаргын болон газрын доорх усандр үзүүлэх нөлөөлөл

Нүүрс ачиж буулгах тээврийн хэрэгслээс алдагдах шатахуун, кемпийн үйл ажиллагаанаас ил задгай хог хаягдал гадаргын урсацаар зөөгдөн тархах болзошгүй гэвч энэ тохиолдол үүсэхгүй байх магадлалтай. Учир нь бодис, нэгдлүүд нь сав баглаа боодлын хувьд битүүмжлэл сайтай.

- Хавар цас хайлах, зун намар эрчимжил ихтэй хур бороо орох үед замыг хөндлөн огтолж буй сайр, судгуудад богино хугацаанд урсац үүсэж, үерлэж болзошгүй.
- Хур тунадас, ялангуяа эрчим ихтэй бороогоор сайр, судгууд үерлэн зам, ус зайлзуулах байгууламжийг эвдлэх тохиолдол үүсэж болзошгүй.
- Төслийн орц гарцын хаалга ус орохооргүй байхаар хийх, төлөвлөх.
- Замын ус өнгөрөөх гаргалгаа зэрэг нь салхи ба усны урсгалаар байнга зөөгдөх хагшаасаар дүүрч хур борооны болон уруйн үерийн үед бөглөрч зохиомол үер үүсгэж, зам болон ус өнгөрөөх байгууламжийг эвдэлж, сэтэлж, гуу жалга үүсгэн нурааж болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усандр үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Тус төслийн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад гаалийн хяналтын бүсийн хэсэгт байрладаг бөгөөд орон сууц олон нийтийн байгууламж бүхий хэсэг нь 1.1 км-ийн зайд үйлдвэрийн бүсэд байрладаг. Үйлдвэрийн байршилын хувьд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.

3.10 Хуримтлагдах нөлөөлөл

“Ийзи транс” ХХК-ийн Гаалийн хяналтын талбай төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт хэрэгжиж байгаа бөгөөд тухайн бүс нутагт үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа явагддаг ба төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт зэрэг болон

Сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг дорийтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад баригдах барилга байгууламжийг барьж байгуулах, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа, орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

Хүснэгт 24. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл	Төслийн талбай, нөлөөллийн бүс,	Өнгөрсөн, одоо, ирээдүй
2	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал		Одоо, ирээдүй
3	Ургамалын нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа		Өнгөрсөн, одоо, ирээдүй
4	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, бусад төслүүдийн ба хотын бохирдлын давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй
5	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	71 600 000 төг
	2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	41 250 000 төг
	3. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	11 250 000 төг
	4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	-
	5. Түүх соёлын өв хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
	6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	3 300 000
	7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5 600 000 төг
	8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлاغнах төсөв	-
	9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	8 000 000 төг
	10. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	2 200 000 төг

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

“Ийзи транс” ХХК-ийн Гаалийн хяналтын талбай төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

№	Төлөвлөсөн хэмжээ	Арга	Урьдчилан тооцсон төсөв Мян.төг	3
	1	2		
1.	“ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Ногоон байгууламж бүхий мод 1000 ширхэг тарих	11250.0	Энэ жилийн хувьд БО хамгаалах санд 1000 мод тарих ажлыг нэгдсэн нэг газар тарина гэсэн тул орон нутгаас чиглэн өгсний дагуу мөнгө тушаасан. Баримтыг хавсаргав.	
2.	Авто тээврийн зогсоолын 5000мкв талбайд хайрга асгаж сайжруулах,	30000.0	Төслийн талбайн орц гарц болон зогсоолын 5000мкв хайрган хучилт хийллээ. Дараа жил үлдсэн зогсоолын хэсгийг хайрган хучилттай болгоно. 	
	Нийт	41250.0		

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ийзи транс” ХХК-ийн Гаалийн хяналтын талбай төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөж биелэлтийг ханггууллаа.

Хүснэгт 25. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Үрьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
Бүтээн байгуулалтын үе шатанд	Aгаарын чанар	<ul style="list-style-type: none"> Машин техникийн хөдөлгөөнөөс ихээхэн хэмжээний тоосжилт үүсэх Бүтээн байгуулалтын үед дуу шуугианы бохирдол үүсэх 	<ul style="list-style-type: none"> 5000мкв зогсоолын талбайг хайргаар хучиж тоосноос сэргийлэх Төслийн талбайг Төслийн талбайг тоос шорооноос сэргийлж 6 метрийн өндөртэй барьцан байгаа хашаагаа засч сэлбэх 	<p>Төслийн орц гарцыг 5000мкв талбайг битүү хайрган хучилттай болгосон.</p> 

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
			<p>Нийт төслийн газрын зогсоолын 1000мкв талбайг хайргаар хучсан. Дараа жил дахин нэмэлтээр зогсоол хэсгийг үе шаттайгаар хучна.</p> <p>Тоосжилтоос сэргийлэх биметр бүхий өндөр хашааг 4 талаараа барьсан байгаа. Түүнийг шалгаж, эвдэрхий хэсгийг сайжруулж зассан .</p> 	

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
Хөрсөн бүрхэвч		<ul style="list-style-type: none"> Бүтээн байгуулалтын үйл ажиллаагаар хөрс эвдрэх, цөлжилт болох эх үндэс бий болох Хог хаягдаар хөрс бохирдох 	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлыг зориулалтын саванд ангилж хийх 	

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
Үйл ажиллагааны үе шатанд	Агаарын чанар	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны үед тоосжилт бий болох Үйл ажиллагаанд оролцох машин техникиэс хорт агууламж бүхий утаа ялгарах 	<ul style="list-style-type: none"> Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг хөрс барьцаалдуулагч шингэнээр нягтаршуулах, тусгай материал тороор хучих, ургамалжуулах зэргээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах 	 
	Гүний ус	<ul style="list-style-type: none"> Гаалийн хяналтын талбай болон ажилчдын хотхон нь усыг төлөвлөгөөний дагуу бус хэтрүүлэн хэрэглэснээс гүний усны нөөц хомсдох Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх 	<ul style="list-style-type: none"> Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/ 	<p>Асгаралтын иж бүрдэл байршуулсан.</p> 

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
Хөрсөн бүрхэвч	Хөрсөн бүрхэвч	<ul style="list-style-type: none"> Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг арга зүйн дагуу хийгээгүй тохиолдолд хөрсөн бүрхэвч доройтох, нөхөн сэргэх чадвараа алдах Хөрсөн бүрхэвчийг талхагдахаас сэргийлж олон салаа зам үүсгэхгүй байх, нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих 	 	

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
	Амьтны аймаг	<ul style="list-style-type: none"> Гаалийн хяналтын талбайд зэрлэг амьтад нэвтрэх, 	<ul style="list-style-type: none"> Төслийн талбайг хамгаалах стандартын дагуу 10-12 метр өндөр бүхий сэндвич хааша татах, засах 	
Нийт			31000.0	31000.0

ЗУРГАА.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Биелэлтийн үр дүн
---	---	-------------------------------	---------------------------	-------------------

“Ийзи транс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн Цагаан хаданд хэрэгжсийж буй “Гаалийн хяналтын талбай”-төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлан

1	2	3	4
1.	<p>“ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний аянд нэгдэх (<i>Тайлбар: Төслийн “Улаанбаатар хотын талбайд 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн Эхний жил тарьц, суулгацын ААНБ-1000ширхэг ын судалгаа</i>) “<i>Тоонот мод тарих байгаль</i>” ТББ-ын үнийн дүнгээр авав.)</p>	<p>БО-ыг хамгаалах санд мөнгө тушаасан. Баримтыг хавсаргав.</p>	
Нийт		--*--	

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГАЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ				
№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4
1.	Ажилчид болон үйлчлүүлэгчийн бие өвдөх, халдварт өвчин гарах	Ажилчдын эрүүл мэндийн үзлэг	Нийт ажилчид	Улаанбаатар хотын Улсын нэгдсэн 4-р эмнэлэгт жил болгон бүх ажилчдаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийлгэдэг. Гэрээг хавсралтаар оруулав.
2.	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр төслийн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах /, утааны мэдрэгч, гал гарсан тохиолдолд ашиглах зориулалттай галын автомат гидрант, аврах шат, хаалга, тэдгээрийн байршилын тойм зураглал, яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбоо зэргээр бүрэн тоноглох/	Нийт ажилчид	  <p>“Ийзи транспорт” ХХК -ийн кемп Аврах гарцын схем</p> <p>1-оффис , 2-Хурлын танхим , 3-Гал тогго , 4-Холлох врее , 5-Ажилчдын алмрак вренинүүд , 6-Ажилчдын алмрак вренинүүд 7-Халалтын зуухмын вренинүүд , 8-Аринуун цэврэйн вренинүүд , 9-Хувцас солих врее , 10-Хүнсний агуулзах , 11-Коридор</p>

“Ийзи транс” ХХК -ийн Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн Цагаан хаданд хэрэгжсийж буй “Гаалийн хяналтын талбай” -төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлан

Нийт						3300.0		
-------------	--	--	--	--	--	---------------	--	--

ЕС.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ				
№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн үр дүн
1	2	3	4	
1.	Ахуйн	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх, Сумын ТҮК-ээр тээвэрлүүлэх, Хог хаягдлын төлбөрийг цаг тухай бүрд төлөх	Хог хаягдлын ангилсан цэг байгуулах, хогны гэрээний дагуу төлбөр төлөх,	<p>Хогны гэрээний дагуу төлбөр 1.98 сая төгрөг төлсөн баримтыг хавсаргав.</p> 

2.	Үйлдвэрийн	Төслийн талбайн орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх	Хог хаягдлын ангилсан цэг байгуулах		
----	------------	---	-------------------------------------	--	--

3.	Аюултай	<p>Нэг удаагийн хэрэглээний зүйлээс татгалзаж, дахин ашиглах,</p> <p>Аюултай хог хаягдал аккумулятор, ашигласан тос маслыг цуглуулах тусгай хаягдлын цэг бий болгох,</p> <p>Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн компанийтай гэрээ байгуулах</p>	<p style="background-color: #FFFF00; padding: 5px;">Хавсралтаар гэрээнүүдийг оруулав</p> <p>Тусгай хог хаягдлын цэг байгуулах</p>	 <p style="text-align: center;">Зураг 5-7 Хаягдал тосны сааны хадгалаалт</p> 

БАТЛАВ:
 “ХАНБОДДЫЙСТ МЕНЕЖМЕНТ ЦЕНТР” ХХК
 ЗАХИРАЛ
З. Аюул №: 11
 Гүйцэтгэх хамрал
 Гүйцэтгэх хамрал
ШУХУУ: SHINU
АЮУЛТАЙ ХОСХАГДЛЫГ ЦҮГЛУУЛАХ ТЭЭВРЛЭХ,
ТҮР ХАДГАЛАХ, УСТГАХ УЙЛ АЖИЛЛАГДАНЫ ГЭРЭЭ

2/Хон/05/арийн/одор №К-6
 Ханбогд сум

Энэхүү Аюултай хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, түр хадгалах, устгах, уйл ажиллагданы гэрээ шашинд “Гэрээ” гэхц.

Ний талас Омноговь аймаг, Ханбогд сум, 2-р баат, Гоботын 4-р тутамж, 4 тоот хүнт байршил Ханбогд Вэйл Менежмент Центр ХХК-ийг төвлөрж. Дэл залжир албан тушаалтай Бантай овогтой Банжигтох (шансид “А” тал гин)

Нийгээ талас “Ногооний Хүргэн” ХХК түүний төвлөрж Гүйцэтгэх залжир албан тушаалт SHINU (шансид “Б” тал, хамада нь “Талууд”) гэх наар дараах ихэцүүлээр 2023 оны 5 дугаар сарын 01-ний одрөс 2024 оны сарын 5-р сарын сарын 30-ний одор хурдлыг 1 жилийн хугацаанд гирээндээ хүрүүлж тогтолцож, гэрээ, дүрэм, журам, стандартыг дагах мөрдэно.

1.1. Гэрээнд оролцож Талууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Байгаль орчны тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 23.1, 21.3 Эрүүл монголийн замын сайдын хог хаягдлын болон ариутгалустайлан А 505 тушаал. Аюултай хог хаягыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин болсгонруулж, устах болин бүртгэх, тайланыхаа журам, Орон пүтгэн иргэний төлөөгүйдийн хүрүүлж тогтолцож, шийдвэр, засаг залжирваны болон бусад хууль тогтолцож, гэрээ, дүрэм, журам, стандартыг дагах мөрдэно.

1.2. Талууд нь тус Гэрээний Б талын Ханбогд суманд байрлах нүүрс ачиж буулгах тайлбарын уйл ажиллаганын үүсч аюултай ангисанд багах хог хаягдлыг бууруулж, изөврэх, ангисах, цуглуулж, тээвэрлэх, устах, булаачаа чиглэхэр хамтран ажилж, харисан туслахын үүрээхэд гэрээнд хөгжлийн орчинь.


1.3. Энэхүү Гэрээ нь аюултай хог хаягдлыг бууруулж, ангисах, тээвэрлэх, устах, булаачаа ажилжсан хамтран хамтрын ажилжилжтэй холбогтой харисан зохицуулна.

1.4. Энэхүү Гэрээнд талууд харисан тусгын эрхтэйгээр оролцно.
 1.5. Гэрээний хамрас хүрээнд Ханбогд сумын Хайрхан багийн Цаглан хаданд байрлах “Б” талын

“Ийзи транс” ХХК -ийн Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн Цагаан хаданд хэрэгжсийж буй “Гаалийн хяналтын талбай” -төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлан

4.	Шингэн	Бохирын цэг	Бохир соруулах	12. Боловсон ариун цэврийн нойдын зураг		БОХИР УС СОРУУЛАХ, ТЭЭВРЛЭХ ГЭРЭЭ 2023 оны 04-р сарын 06-ны одор №: 14 Ханбогд сум Энэхүү гэрээ нь талас хангач төвийг төлөөлж “ХАНДИЗЕЛЬ” ОНӨААТУГТ РД:201563/ (шавийн “Хангаг” гах, түүчиний төлөөлж захидал Цэдэнибакир овогтой Иргээрийн, ногое талаас Ц.Д.Иргээрийн (шавийн “Хэрэглэгч” гэх), Монгол Улсын Иргээний хувь, Хот суурини ус хангамж, ариутах татууртын ашиглалтын тухай хууль болон холбогдох эрэ зүйн актуудыг үндэслэн дараах нохцелоор хариулсан тохиолдож байгуулав. Нэг. Нийтлэг үндэслэл 1.1. Энэхүү гэрээсээр Хангагч нь Хэрэглэгчийн бохир усыг соруулах, тээвэрлэх, Хэрэглэгч нь төлөөр төлөх үргүйг худоно. 1.2. Хангагч байгууллага нь хуульд засны дагуу уг үйл ажиллагааг ивуулаха тусгай зөвшнөөрээш болно. 1.3. Хэрэглэгч болон Хангагч байгууллага нь сөр, өөрний эзэмшилд байгаа бохир усны шугам хохой, худаг, ариутгал халдваргүйжүүлэлт, ашиглалт хамгаалалтад хяналтавна. Хоёр. Гэрээний хугацаа 2.1. Гэрээний хугацаа: Гэрээ байгуулсан одоос эхэн 1 /нэг/ жилийн хугацаатай байна. Гурав. Төлбөр 3.1. Хангагчийн хэрэглээний бохир ус соруулах машин 15м ³ -ийн багтаамжтай, Цагаан хадны сууриншийн бүсээс Ханбогд сумын төвд байрдах цэвэрлэх байгууламжид тээвэрлэн бүлгэхтэй холбогdon гарах зардал нь 1м ³ бохир усанд ИЮАТ орсон дундаж 66,000 эзарн зураган минтгүй тогроогоор тооюон Хангагч талд толно. 3.2. Хэрэглэгч тал ажил ўйличилгэний төлбөр болох 1,100,000 /ИЮАТ орсон/ тогроогийн үржилчлагас байршилах ба энэ төлбөр нь дараагийн ажил ўйличилгэний төлбөрөөс сүүтгэдэх болно. 3.3. Хангагч сар бүрийн 20-ны дотор Хэрэглэгчийн бүртгэлтэй дугаарт төлбөрийн мэдээлийн илрээс багасгд Хэрэглэгч сар бүрийн 25-ны дотор багасгах төлбөр тооюог Хангагч байгууллагын Торийн банкны 211000143222 тоот, Хан банкны 5595001088 тоот данснуудад ўйличилгээний нийэмжжэхийн дагуу бүрэн толно. Дөрөв. Бохир ус соруулах, тээвэрлэх байгууллагын эрх, үүргээ 4.1. Хангагч нь Монгол Улсын Иргээний тухай хувь, Хот суурини ус хангамж, ариутгах
	Нийт					2,400,000.0





Зураг 18. Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон Өрхийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015 стандартын шаардлага-
<https://fb.watch/n1CpsuPIBD/>


Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэрээр нь барилгын болон ажилчдын буюу ахуйн гэж хоёр ангилаа. Шинж чанараар нь хатуу, шингэн, хий гэж хувааж болно.

Төслийг хэрэгжүүлэх явцад барилгын ажилчдын түр суурин байгуулах ба үүсэн гарах ахуйн хог хаягдлыг дараах журмаар зохицуулна. Ялгаатай гурван өнгийн хог ангилан цуглуулах савыг барилгын ажилчдын түр сууринд байрлуулна. Доорх хүснэгт үзүүлсэн хаяг болон зааврыг сав бүрд байрлуулна. Эдгээр саванд хогийг зааврын дагуу ангилан хийж байгаа эсэхэд тухайн төслийн байгаль орчин эсвэл эрүүл ахуйн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.



АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Биелэлтийн үр дүн																																
